




ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



## БАРИЛГЫН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА



[www.1212.mn](http://www.1212.mn)



Улаанбаатар хот  
2024 он

**ХЯНАСАН:**


Д.Мөнхзул

ЧД-ийн Статистикийн хэлтсийн  
дарга

**ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:**

Ч.Элбэгжаргал

ЧД-ийн Статистикийн хэлтсийн  
мэргэжилтэн



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС  
МОНГОЛ- УЛС, УЛААНБААТАР ХОТ  
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, САМБУУГИЙН ГУДАМЖ  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ III БАЙР, 401 тоот  
Утас: 70113013  
70130767  
70110767  
11-310767  
51-261125

Цахим хуудас: [www.ubstat.mn](http://www.ubstat.mn)

И-мэйл: [chingeltei@nso.mn](mailto:chingeltei@nso.mn)

АГУУЛГА

БҮЛЭГ 1. БАРИЛГЫН САЛБАРЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, АНГИЛАЛ, ХАМРАХ

ХҮРЭЭ .....	4
1.1 Барилгын салбарын тухай ойлголт, тодорхойлолт.....	4
1.2 Хамрах хүрээ, ангилал .....	5

БҮЛЭГ 2. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН БАРИЛГАЖИЛТ БА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.1 Чингэлтэй дүүргийн барилга, байгууламж, бүтээн байгуулалтын тухай .....	7
---	---

## 1. БАРИЛГЫН САЛБАРЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

### 1.1 Ойлголт, тодорхойлолт




**Объект:** Бие даасан барилга (орон сууц, үйлдвэрийн гол корпус, сургууль, цех, агуулах) буюу байгууламж (зам, гүүр, далан, суваг, нүхэн гарц) түүнтэй холбогдож хийгдэх үндсэн ба туслах чанарын бусад байгууламж, гадна инженерийн бүх төрлийн шугам сүлжээ, хийц тоноглол, барилгын талбайд хийгдэх өндөржилт, тохижилтын бүх ажил.



**Орон сууцны бус барилга:** Барилгын багахан хэсгийг (нийт талбайн 50 хувиас бага хэсэг) орон сууцны зориулалтаар ашигладаг барилгыг оруулна.

**Орон сууцны барилга:** Хамгийн багадаа түүний тал хэсгийг нь орон сууцны зориулалтаар ашигладаг байгууламж.



**Барилга, байгууламж:** Олон төрлийн зориулалтаар шинээр буюу өргөтгөл, шинэчлэл хийх, нэгдсэн зураг төслөөр баригдах байгууламж

**Инженерийн барилга, байгууламж:** Төмөр зам, зам, гүүр, хурдны зам, онгоцны буудлын талбай, усан хангамж, бохирын шугам, далан хаалт, усжуулалтын байгууламж зэрэг барилга угсралтад ангилагддаггүй барилга, байгууламжийн бүх ажил.



**Угсралт, их засварын ажил:** Барилга, байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагаа.

## 1.2 Хамрах хүрээ

Барилгын салбарт эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC 4.0)-ын дагуу барилга угсралт, иргэний зориулалттай инженерийн байгууламжийн угсралтын үйл ажиллагаа, барилгын тусгай үйл ажиллагаа гэсэн 3 дэд салбарын ажиллагааг хамруулан авч үздэг.

**Барилга угсралтын үйл ажиллагаа (41).** Энэ нь нь дотроо 1 ангитай. Үүнд:

- Барилга угсралт (4100). Энэ ангид өөрийн хөрөнгөөр, төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр гүйцэтгэж ашиглалтанд орсон орон сууцны болон орон сууцны бус барилга байгууламжуудыг барих үйл ажиллагаа багтана. Тухайн барилгын зарим хэсгийг өөр гүйцэтгэгч байгууллага эсвэл бүхлээр нь тухайн гүйцэтгэгч байгууллага гүйцэтгэж болно. Хэрэв зөвхөн барилгын үйл ажиллагааны тусгай хэсгийн үйл ажиллагаа байвал үйл ажиллагаа нь дэд салбар 43-т ангилагдана. Энэ ангид дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:
- Орон сууцны бүх төрлийн барилга байгууламж барих үйл ажиллагаа, нэг өрхийн байшин, олон давхар байшин, олон өрхийн орон сууц.
- Орон сууцны бус барилга байгууламжийг барих үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалттай барилга байгууламж, үйлдвэрийн зориулалттай, сургалтсеминар, хурал цуглаан хийх зориулалт бүхий танхим, өрөө; эмнэлэг, сургууль, конторын барилга; зочид буудал, дэлгүүр, худалдааны төв, зах, ресторан; онгоцны буудал; спортын байгууламж; газар доорх машин тавих зогсоолыг оруулан машины зогсоол; барааны агуулах; шашны зориулалттай барилга, байгууламж, сүм хийд - үйлдвэрлэлийн барилгыг барих, угсрах үйл ажиллагаа. Түүнчлэн орон сууцны зориулалт бүхий барилга, байгууламжийг шинэчлэх, сэргээх үйл ажиллагаа хамаарна.

**Иргэний зориулалттай инженерийн байгууламжийн угсралтын үйл ажиллагаа (42).** Энэ нь 3 бүлэг, 3 ангитай. Үүнд:

- Төмөр зам болон авто замын байгууламж барих үйл ажиллагаа
- Нийтийн аж ахуйн барилга угсралт
- Иргэний инженерийн бусад байгууламж үйлдвэрлэл

**Барилгын тусгай үйл ажиллагаа (43).** Энэ нь 3 бүлэг, 7 ангитай. Үүнд:


- Барилгыг буулгах / нураах үйл ажиллагаа
- Барилгын талбай бэлтгэх үйл ажиллагаа
- Цахилгааны байгууламж суурилуулах үйл ажиллагаа
- Ус, дулааны шугам сүлжээ, агааржуулагч суурилуулах үйл ажиллагаа
- Барилгын бусад суурилуулах үйл ажиллагаа
- Барилгыг дуусгах шатны ажил
- Барилгын бусад тусгай үйл ажиллагаа

ЗУРАГ 1. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ИНФОГРАФИК



## БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, 2023 оны байдлаар

ᠪᠠᠷᠢᠯᠭ᠎ᠠ ᠤᠭᠰᠢᠷᠠᠯᠲᠤ, ᠶ᠋ᠢᠰᠪᠠᠷᠢᠨ ᠠᠵᠢᠯᠢ





## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН БАРИЛГАЖИЛТ БА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж байгаа барилга байгууламж, барилга угсралт, их засварын ажил, инженерийн барилгын ажлууд болон барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн 2023 оны жилийн эцсийн байдлаарх статистик тоон мэдээллийг танилцуулж байна.


Дүүргийн хэмжээнд бизнес регистрийн санд 2023 оны жилийн эцсийн байдлаар 23363 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагаас 656 буюу 2.8 хувь нь барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байна.

### ХҮСНЭГТ 1. АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, дүнгээр

Он	Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын тоо	Үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын тоо	Барилгын салбарт бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын тоо
2019	16 601	715	1 385
2020	17 506	660	1 481
2021	20 103	547	1 653
2022	21 301	6 446	2 050
2023	23 363	7 066	656

Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт аж ахуйн нэгж, байгууллагын дүнд барилгын салбарын аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувийг 2019 он буюу 5 жилийн өмнөх дүнтэй харьцуулахад 1.4 дахин, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.4 дахин тус тус өссөн үзүүлэлттэй гарсан байна.

ЗУРАГ 2. БАРИЛГЫН САЛБАРТ БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, хороогоор



Дүүргийн хэмжээнд барилгын салбарт бүртгэлтэй байгаа аж ахуй нэгж, байгууллагын тоог хороогоор авч үзэхэд 6-р хороонд хамгийн их буюу 65 (9.9%) байгаа бол 21,22-р хороонд хамгийн бага буюу 1 (0.2%) аж ахуй нэгж, байгууллага байна.


ХҮСНЭГТ 2. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, сая төгрөгөөр, 2019-2023 он

Үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Хөрөнгө оруулалт, сая төгрөгөөр	123 489	88 478	73 339	49 437	136 367.9
Хөрөнгө оруулалт, өмнөх онтой харьцуулсан, өсөлт, бууралт, хувиар	20.2%	-28.4%	-17.1%	-32.6%	2.8 <sup>1</sup>

<sup>1</sup>-дахин



ЗУРАГ 3. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, сая төгрөгөөр, 2019-2023 он




Барилга угсралтын ажилд орон сууцны болон орон сууцны бус барилга, инженерийн барилга байгууламж багтаж 2019 онд 123.4 тэрбум байсан бол 2020 оноос 88.5 тэрбум төгрөг, 2021 онд 73.3 тэрбум төгрөг, 2022 онд 49.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тус тус хийгдэж буурсан боловч 2023 онд 136.4 тэрбум болж өссөн үзүүлэлттэй гарсан байна.

ХҮСНЭГТ 3. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, дүүргийн дүнгээр, сая төгрөгөөр, 2023 он

Барилгын төрөл	Хөрөнгө оруулалт /сая төгрөг/	Дүнд эзлэх хувь
<b>Нийт дүн</b>	<b>136367.9</b>	<b>100%</b>
Орон сууцны барилга	24001.2	17.6%
Орон сууцны бус барилга	9680.8	7.1%
Сургууль, цэцэрлэг	18711.2	13.7%
Авто зам, бусад зам	20609.4	15.1%
Эрчим хүчний	2274.8	1.7%
Эмнэлэг	11945.5	8.8%
Их засвар	18383.1	13.5%
Далан, суваг, шугам	1260.4	0.9%
Худалдаа, үйлчилгээний	14612.4	10.7%
Конторын	6109.1	4.5%
Холбооны	4900.0	3.6%
Сүм хийд	1400.0	1.0%
Спорт, биеийн тамир	2480.0	1.8%

Энэ онд дүүргийн хэмжээнд хийгдсэн хөрөнгө оруулалтын дийлэнх хувийг буюу 17.6 хувийг орон сууцны барилга, байгууламж эзэлж байна.

ЗУРАГ 4. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, дүүргийн дүнгээр, сая төгрөгөөр, 2023 он





ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН  
ХОРОО

# СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Хайх ...




СТАТИСТИКИЙН

мэдээллээ аваарай

**Data lab**

тооллого судалгааны  
микро мэдээллийн сан



**Social network**



/StatisticMGL

**Лавлах утас**



**1900-1212**

**Цахим шуудан**



**information@nso.mn**